



## МХЗХҮХ-НЫ ЧИГ ҮҮРГИЙН ХОРООНЫ ЖУРАМ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү журмаар МХЗХҮХ-ны дүрмийн 16-р зүйлд тусгагдсан чиг үүргийн хороодын үйл ажиллагааг зохицуулна.
- 1.2. Энэхүү журмыг МХЗХҮХ-ны тэргүүлэгчдийн зөвлөлийн хурлаар батлагдан байгуулагдсан бүх хороо, дэд хороод үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.

### ХОЁР. ЧИГ ҮҮРГИЙН ХОРООД

- 2.1. Үндэсний холбооны зорилго, зорилтуудыг хангах үүднээс холбооны дэргэд Хөгжил, бодлогын болон Үйл ажиллагааны гэсэн үндсэн 2 чиг үүргийн хороо ажиллана.
- 2.2. Чиг үүргийн хороод нь ажлаа Тэргүүлэгчдийн зөвлөлд хагас, бүтэн жилээр тайлагнана.
- 2.3. Хөгжил, бодлогын хороо нь Хамтын ажиллагааны, Бодлого, зохицуулалтын гэсэн 2 дэд хороотой байна. Үүнд:
  - 2.3.1. Хамтын ажиллагааны дэд хороо нь гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллагуудтай харилцах, лобби хийх, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх шинэ түнш, харилцагчтай болох чиглэлээр ажиллана;
  - 2.3.2. Бодлого, зохицуулалтын дэд хороо нь бизнес төлөвлөгөө, төсөв, төсөл, хөтөлбөрийн тооцоо, эрх зүйн орчинг сайжруулах чиглэлээр ажиллана.
- 2.4. Үйл ажиллагааны хороо нь Гишүүнчлэлийн, Сургалт, судалгааны, Зөвлөх үйлчилгээний гэсэн 3 дэд хороотой байна. Үүнд:
  - 2.4.1. Гишүүнчлэлийн дэд хороо нь хоршоодын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, тэдгээрийн удирдлага, ажилтнуудын хоорондын харилцаа, түншлэлийг өргөжүүлэх, гишүүнчлэлийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн төрөл бүрийн нийгмийн арга хэмжээг зохион байгуулах чиглэлээр ажиллана;
  - 2.4.2. Сургалт, судалгааны дэд хороо нь зах зээлийн судалгаа хийх, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ боловсруулах, нэвтрүүлэх, сургалт зохион байгуулах, сургалтын материал боловсруулах, хэвлэх, сургагч багш нарыг бэлтгэх чиглэлээр ажиллана;
  - 2.4.3. Зөвлөлгөө, үйлчилгээний дэд хороо нь гишүүн хоршооддоо мэргэжлийн чиглэлээр зөвлөлгөө өгөх, зөвлөхүүдийг бэлтгэх үндсэн үүрэгтэй ажиллана.
- 2.5. Тэргүүлэгчдийн зөвлөл, гүйцэтгэх албаны санаачлагаар цаг үеийн тодорхой асуудлыг боловсруулах үүрэгтэй нэгж, ажлын хэсгийг байгуулж болно.

## ГУРАВ. ДЭД ХОРООДЫГ БАЙГУУЛАХ, БҮРЭЛДЭХҮҮН

- 3.1. Тэргүүлэгчдийн зөвлөлийн шийдвэрээр дэд хороод байгуулагдах бөгөөд дэд хороо бүрийг хариуцаж ажиллах тэргүүлэгчдийг Тэргүүлэгчдийн зөвлөлийн хурлаар томилно.
- 3.2. Холбооны дарга, дэд даргаас бусад тэргүүлэгчид заавал аль нэг дэд хороонд харьяалагдана.
- 3.3. Дэд хороодыг хариуцан ажиллах тэргүүлэгч гишүүн нь дэд хороодтой холбогдолтой асуудлыг Тэргүүлэгчдийн зөвлөлийн хуралд оруулж шийдвэрлүүлэх үүргийг хүлээнэ.
- 3.4. Дэд хороод нь хариуцсан тэргүүлэгч гишүүнээс гадна 5 хүний бүрэлдэхүүнтэй байна.
- 3.5. Дэд хороод нь мэргэжлийн ур чадвар, туршлага бүхий сайн дураараа ажиллах хүсэл сонирхолтой хүмүүсээс бүрдэнэ.
- 3.6. Дэд хороод нь дарга, нарийн бичигтэй байх бөгөөд даргыг Тэргүүлэгчдийн зөвлөл томилж, нарийн бичгийг өөрсдөө томилно.
- 3.7. Дэд хороодын бүрэлдэхүүнийг гүйцэтгэх захирлын саналыг үндэслэн Тэргүүлэгчдийн зөвлөлийн хурлаар сонгон шалгаруулах замаар томилно.

## ДӨРӨВ. ДЭД ХОРООДЫН АЖИЛЛАХ ЗАРЧИМ

- 4.1. Дэд хороод нь Холбооны жилийн ерөнхий төлөвлөгөөний хүрээнд ажлын төлөвлөгөөгөө бүтэн жилээр боловсруулан Тэргүүлэгчдийн зөвлөлөөр батлуулан ажиллана.
- 4.2. Дэд хороод боловсруулсан, хэлэлцүүлсэн санал, аливаа асуудлыг хариуцсан Тэргүүлэгчдийн зөвлөлийн гишүүнээр дамжуулан Тэргүүлэгчдийн зөвлөлийн хуралд оруулж шийдвэрлүүлнэ.
- 4.3. Дэд хороодын дарга нь хорооны үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах бөгөөд Гүйцэтгэх захиралтай нягт хамтран ажиллана.
- 4.4. Дэд хорооны нарийн бичиг нь тухайн дэд хороотой холбоотой баримт бичгийн бүрдэл, хадгалалт, хамгаалалтыг хариуцна.
- 4.5. Чиг үүргийн дэд хороонд үр бүтээлтэй ажиллаж буй гишүүдийг салбарын хэмжээний аливаа арга хэмжээ, сургалтанд тэргүүн ээлжинд хамруулан оролцуулах зарчмыг баримтлана.

\*\*\*\*\*